



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 05 сарын 04 өдөр

Дугаар А/177

Мандалговь

Мал бүртгэлжүүлэлтийн аян
зохион байгуулах тухай

Малын генетик нөөцийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1, 5.2 дахь заалт, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2019 оны А-501 дүгээр тушаалаар баталсан “Малын бүртгэлийн журам”-ын 2.1.1, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн А-72 тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал үржүүлэг технологийн ажил үйлчилгээний хавар, намрын технологид хугацаанд “Мал бүртгэлжүүлэлтийн аян”-ыг зохион байгуулсугай.

2. Тухайн аяны удирдамжийг нэгдүгээр хавсралтаар, бүртгэлжүүлэх малын төрөл, тоо хэмжээг хоёрдугаар хавсралтаар, хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Аяны хүрээнд малыг ялган тэмдэглэж, бүртгэлжүүлэх, бүртгэл мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх ажлыг нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газар (Б.Мөнхжаргал)-т, орон нутагт ажиллах хүчнийг зохион байгуулж, технологид хугацаанд багтаан чанартай, үр дүнтэй зохион байгуулж тайланг хагас, бүтэн жилээр гаргаж ирүүлэхийг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

48121049E